

Хүүхдийн Клиникийн сувилал №20

Хүүхдийн Клиник сувилал №20 1961 оны зургадугаар сарын 12-энд Улаанбаатар хотын АДХГЗахиргааны тогтоолоор "Хүүхэд асрах газар нэртэйгээр 100 ортой,22 ажилтантайгаар үйл ажиллагаагаа эхэлсэн түүхтэй.

1991 ЭМСайд, Нийслэлийн Засаг даргын хамтарсан 39/83 тоот тушаалаар "Хүүхдийн сувилал" нэртэй болж,улмаар 2001 онд ЭМСайд, НЗД-ын хамтарсан 98/197 тоот тушаалаар "Хүүхдийн клиник сувилал " болон өргөжиж, Чингэлтэй дүүргийн 18 хорооны 1-3 насны суурь болон архаг өвчтэй хүүхдийг эмчлэн сувилах, бие бялдрын чадав хийг нөхөн сэргээх зэрэг эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг эмчилгээ сувилгааны мэргэжлийн байгууллага болсон. Монгол улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль" Улсын Их Хурлын 2002 оны 56 дугаар тогтоолоор баталсан.

"Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэл" МУ-ын ЗГ-ын 2003 оны 34 тоот тогтоол,НИТХ-ын 2003 оны128 тоот тогтоолыг үндэслэн НДЗ-ын 478 тоот захирамжийн дагуу 2004 оноос удирдлагын гэрээгээр ажиллаж 2007 оны 4- р сард Нийслэлийн хувьчлалын комиссын 38 тоот тогтоолоор хувьчлагдсан.

Тус сувиллын эрхлэгчээр

1961-1968 онуудад бага эмч Цэрэндаваа, Удвал, Жавзан,Дэмидхан.

1968-1983 онд ЭМБ-ын Тэргүүний ажилтан, бага эмч Нямсүрэн

1983-1992 онд ЭМБ-ын Тэргүүний ажилтан, бага эмч Т.Ашваа

1992-2004 онд АУ-ны магистр,хүүхдийн их эмч С.Лхамхүү нар тус тус ажиллаж байв.

2004 оноос АУ-ны магистр тэргүүлэх зэрэгтэй их эмч Н.Цогбадрах захирлаар ажиллаж байна.

2004 онд хамт олон ажил үйлсээрээ тэргүүлж, "Сувилахуйн амьдрал" төвөөс "Сайн цагийн мянган бурхад" хэмээн өргөмжлөгдсөн өргөмжлөлөөр, НЭМГ-ын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ амжилттай хэрэгжүүлж, 2004,2005 оны ажлаар Бүрэн хангалттай үнэлгээ авч НЭМГ-ын "Өргөмжлөлөөр шагнуулсан.

2007 онд Чингэлтэй дүүргийн "Эрүүл орчин бүрдүүлсэн байгууллагаар шалгарсан.

1998-2008 онуудад А. Зохион байгуулалтын талаар

1. Удирдлагын төвлөрсөн эрхийг шилжүүлэн үйл ажиллагааг удирдлагын зөвлөл зохицуулдаг болсон.

2. Чанар хяналтын менежерийг орон тоогоор ажиллуулан хяналтын системийг боловсронгуй болгосон.

3. Мэргэжлийн зөвлөл байгуулж эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг мэргэжлийн төвшинд явуулж эхэллээ.

4. Цагийн менежментийг нэвтрүүлсэн.
5. Ажлын байрны тодорхойлолтыг оновчтой болгосон.
6. Ажилчдын заавал хэвшүүлэх зан үйлтэй болгосон.
7. Хөдөлмөрийн үнэлэмжийг оновчтой болгож урамшууллын системийг нэвтрүүлсэн.
8. Сувилгааны эрүүл аюулгүй орчинг бүрдүүлсэн

Ажилчдын мэдлэг мэргэжлийг тогтмол дээшлүүлэх замаар байгууллагын найдвартай ажиллагааг хангахад онцгой анхаарч ажлын байранд суралцах нөхцөл боломжийг бүрдүүлж өгсөн. Үүнд мэргэжлийн ном гарын авлагаар хангаж, компьютер интернет ашиглах боломжтой болсон. Дотоодын сургалтын нэгдсэн төлөвлөгөөтэй болж, эдгээрийн дүнд эмч эмнэлгийн дунд мэргэжилтний мэдлэг мэргэжил дээшилж 100% лицензтэй байна. Одоо тус байгууллагад тэргүүлэх зэргийн эмч1, Анагаах ухааны магистр 1, бакалавр зэрэгтэй сувиллагч 2 тус тус ажиллаж байна.

1998-2008 онуудад эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн ажлын хариуцлагатай холбоотой санал гомдол гараагүй болно.

Эмчилгээ сувилгааны чанар хүртээмжийг дээшлүүлэх талаар:

Сүүлийн 10 жилийн хугацаанд эмчилгээ сувилгааны чанар хүртээмжийг дээшлүүлэх талаар орчин үеийн эмчилгээ сувилгааны багаж тоног төхөөрөмжөөр хангах, эмч мэргэжилтнийг тогтвор суурьшилтай ажиллуулах, тэдний мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, сувилгааны эрүүл аюулгүй орчинг бүрдүүлэх, зорилтыг үйл ажиллагааныхаа төлөвлөгөөнд шат дараатай тусгаж хэрэгжүүлснээр өнөөдөр сувилгааны эрүүл аюулгүй орчин бүрдсэн. орчин үеийн тоног төхөөрөмж, мэргэжилтэй боловсон хүчнээр бүрэн хангагдсан үлгэр жишээ хүүхдийн сувилал болж чадсан байна.

2004 оноос 5 жилийн дундажаарор ашиглалт 85%-ай жилд 180-200 хүүхэд сувилж байсан бол ор ашиглалтыг 107,5% хүртэл нэмэгдүүлж жилдээ 405 хүүхдийг сувилдаг болсон. Өөрийн сувиллын үйл ажиллагааны онцлогтой уялдсан эмчилгээ сувилгааны болон бусад стандартуудыг боловсруулан мөрдлөг болгон ажиллаж байна. Мөн эмчилгээ сувилгаа, хоолны нэр төрлийг олшруулж өдөр тутмын хоолны илчлэгийг тооцон чанар хүртээмжийг сайжруулж чадлаа. Эдгээрийн дүнд сувилуулж буй хүүхдийн эдгэрэлт 45,5% байсныг 85,5% -д хүргэлээ.

ЭШ Халдвар болон бусад халдварт өвчнийг гаргалгүй ажиллаж байна.

Г. Хөрөнгө оруулалтын талаар:

1998-2004 онд жил тутам 800 мянгаас 1 сая төгрөгийн урсгал засварыг хийж ирсэн бол. 2004-2007 онд барилгын хэсэгчилсэн их засвар, дотоод тохижилт, тоног төхөөрөмжийн хангалтад 46,2 сая төгрөг ний хөрөнгө оруулалт хийсэн байна. 2008 онд сувиллын бригад 50,0 сай төгрөгийн иж бүрэн засвар тохижилтын ажлыг хийлээ.

Үр дүн: Сүүлийн 10 жилд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний дүн үйл ажиллагааны чанар хүртээмж сайжирч , суурь өвчтэй хүүхдийн сувилалд хамралт эрүүлжүүлэхийн байдалд мэдэгдэхүйц өөрчлөлт гарч,санхүүгийн чадавх сайжирч хөрөнгө оруулалт эрс нэмэгдэж сувилгааны эрүүл аюулгүйн орчин бүрдүүлээ. Мөн ажилчдын хэвштэл сэтгэлгээ өөрчлөгдөж миний юм манай юм манай байгууллагын юм гэсэн өөриймсөг арвич хямгач зан үйл тогтоосон.

Үйлчилгээнд соёлтой шуурхай байдал бий болж үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж 98% болж өссөн.